

Эхчүүд болон охид

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч М.Рассел Баллард

Энэхүү эцсийн өдрүүдэд эцэг эх, хүүхдүүд бие биенийнхээ үгийг сонсож, бие биеэсээ суралцдаг байх нь амин чухал, бүр шийдвэрлэгч ач холбогдолтой болж байна.

Ах эгч нар аа, зургаан сарын өмнө, Ерөнхий чуулганы санваартны хуралдаан дээр би аав нар болон хөвгүүдийн талаар үг хэлсэн билээ. Та бүхний хүлээж байгаагаар, Миний 5 охин, 24 ач, зээ охин өөрсдөдөө адил тэнцүү цаг гаргахыг надаас хүсдэг гээд бод л доо. Гэтэл цаашид ач, зээ охидын тоо бүр нэмэгдэнэ шүү дээ. Тиймээс, өнөөдөр би Сүм дэх эхчүүд болон охидод голчлон хандаж үг хэлэх болно.

Хайрт эхнэр Барбара минь, охид, ач, зээ охиддоо мөнхийн ач холбогдолтой нөлөө үзүүлдэг бол тэд ч мөн ээждээ ийм нөлөө үзүүлсээр байна. Эмэгтэйчүүд, эхчүүдийн байр суурь, нэр нөлөөг дэлхий өнгөлөн далдалсан аргаар доогуурт тавьдаг ч гэсэн эхчүүд, охид хязгааргүй боломжоо ашиглан бие биедээ туслахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна.

Бараг зуун жилийн өмнө, Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит Сүмийн эмэгтэйчүүдэд

хандан үг хэлэхдээ: “Та нар дэлхийн эмэгтэйчүүдээр удирдуулах биш харин . . . , дэлхийн эмэгтэйчүүдийг та нар бүх талаар, хүмүүний үрсийг дээдлэн. . .

цэвэршүүлэх юм бүхнээр тэднийг удирдан хөтлөх ёстой” гэсэн билээ (*Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* [1998], 184)).

Эгч нар аа, дэлхийн сууринаас өмнө тэнгэрээс та нараар хийлгэхээр томилсон зүйлсийг ах нар тань болох бид хийж чадахгүй шүү дээ. Бид хичээж болох ч, та

нарын хосгүй өвөрмөц бэлгийг бид хэзээ ч орлож чадахгүй, ингэж бодох ч хэрэггүй юм. Зөв шударга эмэгтэйн хувийн үзүүлэх нөлөөтэй зүйрлэм тийн хүмүүжүүлэх, амьдралыг өөрчлөх хүчтэй зүйл энэ дэлхийд ер байхгүй юм.

Зарим залуу эмэгтэйчүүд, та нарт эдгээр зүйлсийн талаар ярилцах ээж байхгүйг би ойлгож байна. Мөн эмэгтэйчүүд та нарын олон нь одоогоор охидгүй байж болно.

Гэсэн ч, бүх эмэгтэйчүүд тэнгэрлэг мөн чанараараа эх хүний авъяас чадвар, үүрэг хариуцлагыг өвлөн авсан байдаг. Тиймээс эмэг эх, авга, нагац эгч нар эгч, эмэгтэй дүү нар, хойд эхчүүд, хадам ээж нар, удирдагчид мөн заримдаа эдгээр чухал ач холбогдолтой ээж охины харилцаанд адил үүргийг гүйцэтгэдэг хүмүүжүүлэгч бусад бүх хүмүүст хандаж хэлэх зүйлсийн маань ихэнх нь тэдэнд адил тэнцүү хамаатай юм.

Залуу эмэгтэйчүүд ээ, ээж нар тань та нарыг ихэд хайрлан биширдэг. Тэд ирээдүй үеийнхэнд өгөгдсөн амлалтыг та нараас олж хардаг. Та нарын хийх бүх зүйл, та нарын даван туулах ёстой бүх сорилт бэрхшээл тэдэнд цэвэр ариун баяр баясгаланг авчирдаг. Үүн лүгээ адил, *та нарын* сэтгэл санааны зовлон, зүрх сэтгэлийн эмзэглэл нь *ээж нарын чинь мөн* сэтгэл санааны зовлон, зүрх сэтгэлийн эмзэглэл байдаг.

Ээжтэйгээ харилцах харилцаагаа хэрхэн бүрэн дүүрэн бататгах талаар би залуу эмэгтэйчүүд та нарт зарим зөвлөгөөг өгөхийг хүсэж байна. Дараа нь охиддоо гэр бүлийн бусад гишүүдээ нөлөөлөх нөлөөгөө хэрхэн өсгөн нэмэгдүүлж болох талаар ээж нартай хуваалцах зарим бодол санаа байна.

Харамсалтай нь, орчин үеийн нийгэм дэх эмэгтэйчүүдийн байр суурь, үүргийг мушгин гуйвуулж, төөрөгдөл бий болгосныг харах шиг хялбар юм үгүй болжээ.

Даруу бус, ёс суртахуунгүй, биеэ барьдаггүй эмэгтэй хүмүүс радио телевизийн сувгийг дүүргэж, сэтгүүлүүдэд онцгой эрх тогтоон, кино дэлгэцэнд шургалж байна.

Тэднийг дэлхий хөөргөн дэвэргэж байна. Төлөөлөгч Паул эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирнэ гэдгийг, ялангуяа, түүнд тун эвгүй харагдаж байсан зүйлийг: “нүгэлд автагдаж, зүсэн бүрийн хүсэл тачаалдаа хөтлөгдсөн сул дорой эмэгтэйчүүдийг олзолдог хүмүүс ч байна” (2 Тимот 3:1, 6) хэмээн бошиглолоор анхааруулсан билээ. Өнөөгийн олон нийтэд дэлгэрсэн соёл нь ихэнх тохиолдолд эмэгтэйчүүдийг тэнэг мунхаг, бусдад нөлөөлөх чадваргүй, ухаан муутай, сул дорой хэмээн харагдуулдаг. Энэ нь эмэгтэйчүүдийн нэр хүндийг үгүйсгэн, тэдэнд үл хүндэтгэсэн байдлаар хандах явдлаар илэрч байна. Тэр ч байтугай тэд зөвхөн дур таашаал татах төдийгөөр л хүн төрөлхтөнд үл мөрөө үлдээж чадна хэмээн үздэг. Энэ бол эмэгтэйчүүдийн талаар тараадаг хамгийн аюул бүхий, хорон санаатай суртал ухуулга юм.

Тиймээс, эрхэм хүндэт залуу эмэгтэйчүүд ээ, үлгэр жишээний загвар, халамжлан хүмүүжүүлэгч байх үүргийн чинь талаар өнөөгийн нийгэм юу гэж байсан ч, түүнийг огт тоохгүй байхыг би та бүхэнд чин сэтгэлээсээ зөвлөж байна. Дагах үлгэр жишээг итгэлтэй ээж нараасаа олж аваарай. Ээж нараасаа үлгэр жишээ авч, тэднийг даган дуурай, харин “одуудыг” дуурайвал Их Эзэний жишиг тэднийх биш, тэдний

эрхэмлэдэг зүйлс нь мөнхийн хэтийн төлөвөөс гадуур юм. Ээжийнхээ хүч чадал, хатан зориг, итгэлээс суралц. Түүнийг сонс. Ээж чинь мэссэж бичихдээ гарамгай биш байж болно. Тэр битгий хэл фэйсбуукийн хуудасгүй ч байж магадгүй. Харин Их Эзэний болон зүрх сэтгэлийн зүйлсэд ээж чинь арвин баялаг мэдлэгтэй байдаг. Гэрлэх болон залуу ээж болох үед чинь тэр чамд хамгийн агуу мэдлэгийн сан байх болно. Өөр хэн ч чамайг ээж шиг чинь хайрлаж чадахгүй. Энэ дэлхийн амьдралд болон үүрд мөнхөд аз жаргалыг олоход чинь туслан, бүх зүйлд түшиг тулгуур

болдог, чиний төлөө золиослол хийхэд ямагт бэлэн байдаг хүн ээжээс чинь өөр байхгүй шүү.

Залуу эгч нар аа ээжийгээ хайрла. Түүнийг хүндэл. Түүнийг сонс. Түүнд итгэ. Тэр чиний төлөө бүхий л зүйлийг хийх болно. Тэрээр чиний мөнхийн аюулгүй байдал, аз жаргалын төлөө анхаарал халамж тавьдаг. Тиймээс түүнд үрийн сайхан сэтгэлээр ханд. Төгс биш байдалд нь тэвчээртэй ханд. Бид бүгдийн адил ээж чинь ч төгс биш шүү дээ.

Одоо охидынхоо амьдралд онцгой үлгэр жишээг үзүүлэх талаар зарим санаа бодлоо би ээж та нартай хуваалцъя. Манай гэр бүлийн нэгэн найз маань өвөө, эмээ ач зээ гээд өнөр бүлээрээ үе үе аялалд явдаг байлаа. Охид нь ээж нартайгаа хэрхэн адил зан ааш гаргадаг болохыг аялал болгоны дараа түүний хийдэг нэн чухал ажиглалт харуулжээ. Ээжүүд нь арвич хямгач байвал охид нь бас тийм байв.

Ээжүүд нь даруухан зантай байвал охид нь мөн тийм байв. Хэрвээ ээжүүд нь угладаг шаахай, энгийн хувцас өмсөөд ариун ёслолын цуглаанд очвол охид нь бас тийм байлаа. Ээж нар аа, хэдийгээр тэд үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байж мэдэх ч та нарын үлгэр жишээ охидод чинь маш чухал юм шүү.

Дэлхийн түүхийн турш, эмэгтэйчүүд ёс суртахууны эрхэмлэн дээдэлдэг зүйлсийн багш нар байсаар ирсэн юм. Энэхүү сургалт хүмүүжил хүүхдийг бүр өлгийтэй байхаас нь эхэлж, түүний амьдралынх нь турш үргэлжилдэг билээ. Өнөөдөр, манай нийгэм эмэгтэйчүүд, эхчүүдийн талаар аюултай, хүний мөс жудаггүй буруу мэдээллээр бөмбөгдүүлсээр байна. Хэрвээ охид чинь эдгээр мэдээллийг аван дагавал, тэд гэм нүглийн болон өөрийгөө сөнөөх замаар алхаж мэднэ. Та л тэдэнд хэлэхгүй бол, эсвэл сайн сонголтуудыг хэрхэн хийхийг тэдэнд үзүүлэхгүй бол охид чинь үүнийг ойлгохгүй өнгөрч магадгүй юм. Израилын ээж нар бол дэлхийн хууран мэхлэлтийн эсрэг охидынхоо анхны хамгаалалт нь байх юм шүү.

Одоо, эгч нар аа, зарим үед хүүхдүүд өөрсдөд нь зааж байгаа хичээлүүдэд анхаардаггүйг би ойлгож байна. Өөрийн чинь хамгийн хэрэгтэй, хамгийн чухал гэж бодсон зөвлөгөөг хүүхдүүд тань чихнийхээ хажуугаар, тоомсоргүй өнгөрүүлж мэдэхийг би ойлгож байна. Охин чинь таны хэлж байгаа үгсийг огт сонсохгүй байгаа мэт өөрт чинь санагдаж болно. Гэвч тэр таны ажил үйлс, үг яриатай хэрхэн нийцэж байгааг харснаараа танаас суралцаж байдаг гэдгийг та бүхэнд батлан хэлж байна. Ральф Валдо Имерсоны хэлснээр: “Чиний хийдэг зүйлс дэндүү чанга дуугаар ярих учраас хэлэх үгийг чинь би сонсож чаддаггүй” (Ralph Keyes, *The Quote Verifier* [2006], 56).

Хүүхдүүдийг хайрлаж хүмүүжүүлснээр баяр баяслыг олж болохыг охиддоо заагаарай. Үүнд л тэдний хайр, авъяас чадвар мөнхийн ач холбогдолтой байх болно. Ерөнхийлөгч Харольд Б.Лий: “Таны хийх хамгийн чухал зүйл гэр бүлийн чинь дотор байх болно” (*Teachings of Presidents of the Church: Harold B. Lee* [2000], 134) гэсэн зааврыг энэ сэдэвтэй холбон авч үзээрэй. Мэдээж хэрэг, энэ нь бид бүгдийн хувьд үнэн юм. Харин энэ нь ээж охин хоёрын харилцааг хөндөж байгаа үед бүр ч илүү чухал юм.

Ээж нар аа, Бурханы итгэлтэй охид хов жив хөөцөлдөх, бие биеэ шүүх зэрэг уруу таталтаас хол хөндий байх ёстойг охиддоо заагтун. Бошиглогч Иосеф Наувугийн Нийгмийн Халамжийн Бүлгийнхэнд хандаж үг хэлэхдээ: “Хэл бол амардаггүй эрхтэн юм. Хэрэггүй зүйл ярихаас хэл амаа барь” гэж эгч нарт зөвлөжээ. (*Teachings of Presidents of the Church: Joseph Smith* [2007], 455).

Ойрын жилүүдэд, хов жив хөөцөлддөг, “олиггүй” эмэгтэйчүүд, охидын тухай олон өгүүллэг, ном, кинонууд гарсаар байна. Өсгөн хүмүүжүүлэх мөн чанар болох эмэгтэй хүний тэнгэрлэг мөн чанарын хамгийн эрхэм үнэ цэнэтэй тал болох

халамжлан хүмүүжүүлэх үүрэг хариуцлагыг Сатан үргэлж буруутгахыг хичээж байна.

Ээж охин хоёрын харилцаанаас охин нь өөрийг нь хэрхэн халамжлан хүмүүжүүлснээс өөр хэн нэгнийг яаж халамжлан хүмүүжүүлэхийг сурдаг. Түүнийг хайраар өсгөн хүмүүжүүлдэг. Тэрээр өөрт нь итгэж, өөрийг нь дэмжихийн хамт алдаа дутагдлыг нь үргэлж залруулж өгдөг хүнтэй байхын чухлыг туршлагаасаа мэдэж, суралцдаг.

Эгч нар аа, Бурхан бол бүх ёс суртахууны болон сүнслэг хүч чадлын эх сурвалж юм гэдгийг санагтун. Бид Түүнтэй гэрээнүүд байгуулснаар мөн эдгээр гэрээнүүдийг сахиснаар хүч чадалтай болох боломж бүрддэг. Ээж нар аа, охиддоо Ариун сүмд орохуйц зөв зохистой амьдрах хүсэл төрүүлэх үүднээс гэрээнүүд байгуулахын чухлыг тэдэнд зааж, улмаар гэрээнүүдээ хэрхэн сахихыг өөрийн үлгэр жишээгээрээ харуул.

Өнөөгийн дэлхийд, энэ нь бэлгийн харилцааны талаар охидтойгоо ярина гэсэн үг юм. Охид, хөвгүүд тань дэндүү эрт, хөнгөмсөг, болчимгүйгээр бэлгийн харилцаанд орохыг илэн далангүйгээр хүлээн зөвшөөрч байгаа дэлхийд тэд өсч, насанд хүрч байна. Ичгүүргүй, ёс суртахууны хувьд цэвэр ариун бус эмэгтэйчүүдийг ёс бусаар алдаршуулан тэднийг, даган дуурайж байна. Гэр бүл, гэр орноо эдгээр олиггүй муу нөлөөнөөс хамгаалахын тулд бид тодорхой алхмуудыг хийж байгаа ч, охид чинь илэрхий бэлгийн харилцаанд дуудсан ичгүүргүй мэдээлэл, эргэн тойрон дахь өдсөн уруу таталтаас бүрэн зайлсхийж чадахгүй байж мэднэ. Та нар эдгээр асуудлуудын талаарх үнэнийг охиддоо заах үед байнга, илэн далангүй ярилцаж байх хэрэгтэй. Жишээлбэл, тэд дэндүү биеэ барьсан, богинохон, эсвэл хэтэрхий задгай энгэртэй хувцас өмсвөл хамт байгаа залуучуудад зохисгүй санааг төрүүлж болохоос гадна, бас өөрсдийн бодол санаанд эмэгтэй хүний үнэ цэнэ нь гагцхүү гадна талын үзэмж

дээр тулгуурладгийг хүлээн зөвшөөрсөн хэрэг болно. Бурханы итгэлтэй охины зөвт байдлын тодорхойлолт ийм байгаагүй бөгөөд хэзээ ч ийм байх ёсгүй юм. Охид чинь таны амнаас үнэн зөв, шулуун шударга, илэн далангүй үгсийг үе үе сонсож байх хэрэгтэй бөгөөд өөрийн чинь хувцаслалт, биеэ авч яваа байдал, даруу зангаас чинь зөв үлгэр жишээг харж байх хэрэгтэй.

Бүх залуучууд Сүнсний дуу хоолойг болон Сүнс оршин байгааг танин мэдэж сурах юм бол тэд гэрээнүүд байгуулж, улмаар сахих илүү магадлалтай байх болно.

Охиддоо Сүнсний зүйлүүдийг заа. Тэднийг судрууд уруу хөтлөгтүн. Амьдралдаа санваарын хүчний адислалыг хүндэтгэн хадгалах туршлагыг тэдэнд төлөвшүүл.

Гэрээнүүдийг сахиснаар тэд Их Эзэний дуу хоолойг сонсож, хувиараа илчлэлт хүлээн авч сурах болно. Бурхан үнэхээр тэдний залбирлыг сонсож, хариулах болно.

2010 оны Мючелийн сэдэв нь манай залуу үеийнхэн болон бид бүгдэд хамаатай юм: “Тууштай бөгөөд зоригтой бай. Хаана явсан газарт чинь чиний Бурхан Эзэн чамтай хамт байх учраас бүү чичирч айгтун” (Иошуа 1:9). Энэ нь тэднийг Ариун Сүмийн адислалууд уруу аюулгүйгээр хөтлөх болно.

Гэрээнүүдийг сахих нь мөнхийн аз жаргалд хүрэх хамгийн аюулгүй зам гэдгийг тэд мэдсэн байх ёстойг мэдэгтүн. Хэрвээ хэрэгцээтэй бол хэрхэн наманчлахыг, хэрхэн цэвэр ариун, зохистой хэвээр үлдэхийг тэдэнд заа.

Ах эгч нар аа, хэрвээ та бүхэн үүнийг урьд нь сонсож байсан юм шиг байвал, би эцэг эхчүүд болон тэдний үр хүүхдүүдэд хандан гурван Ерөнхий Чуулганд дараалан энэ сэдвээр үг хэлж байна. Өнгөрсөн 4-р сард би залуу үеийнхнийг:

“Өнгөрсөн үеийн сургамжуудаас суралц” хэмээн уриалан дуудсан. Тэр үед хэлсэн үгээсээ эш татъя: “Та нарт анхааралтай сонсож сурах хүсэл байгаа тохиолдолд амьдралын хамгийн үнэ цэнэтэй сургамжуудыг ахмад хүмүүсээс авч болно... Есүс Христийн итгэлтэй, эрэлхэг зоригтой дагалдагчдын үлгэр жишээг дагавал амьдрал

тань илүү сайн байх болно” (“Learning the Lessons of the Past,” *Лиахона*, 2009 оны 5-р сарын 31, 33).

Би өнгөрсөн 10-р сард Санваартны хуралдаан дээр аав нар болон хөвгүүдэд хандан үг хэлсэн билээ. Өнөөдөр би голчлон ээж нар, охидод хандан үг хэллээ. Нөхцөл байдал болгонд миний хэлсэн үг өөр байсан ч утга нь ижил юм. Та бүгд чих тавин сонсож загварыг анхааран харж, бат тогтвортой, тууштай захиасыг сонссон гэдэгт би найдаж байна. Энэхүү эцсийн өдрүүдэд эцэг эх, хүүхдүүд бие биеэ сонсон, нэг нэгнээсээ суралцах нь нэн чухал, тэр ч бүү хэл шийдвэрлэгч зүйл юм. Би бодит бус, амьдралд байдаггүй хийсвэр юмсын талаар яриад байгаа юм биш. Эдгээр нь, бидний мөнхийн амар амгалан, аз жаргалын төлөөх Бурханы төлөвлөгөөний төв хэсэг мөн.

Энэ үйл хэрэгт Сүм чадах чинээгээрээ туслах болно. Эцэг эх, хүүхдүүдэд та нарт бид туслан дэмжихэд бэлэн байна. Гэвч, гэр бүлийг болон маргаашийн Сүмийг удирдахад өнөөгийн залуу үеийнхнийг бэлтгэх хамгийн чухал газар бол гэр орон юм. Эцэг эхчүүд бид залуу үеэ итгэлтэй, зөв шударга эрэгтэй, эмэгтэйчүүд болгон төлөвшүүлэхэд чадах бүхнээ хийх нь бидний хүн нэг бүрийн үүрэг хариуцлага юм. Бид гэр орондоо сайн мэдээг дүрмээр бас үлгэр жишээгээр заах ёстой.

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн бошиглолын дүгнэлтээр би өөрийн зөвлөгөөгөө дуусгая: “Мөнх байдлаас бид энэ амьдралыг ялгахад гэр бүлийн хэлхээ холбоо нь зөвхөн энэ амьдралд, энэ цаг мөчид зориулагдсан биш юм. Бид энэ амьдралд хийгээд үүрд мөнхөд амьдрах болно. Бидний хэлхээ холбоо, нөхөрлөл, харилцаа энэ амьдралд болон үүрд мөнхөд оршдог . . . Дараагийн амьдралд гэр бүлийн харилцаа үргэлжилнэ, аав, ээж, үр хүүхдүүд учран золгоно гэж Хожмын Үеийн Гэгээнтнүүдээс өөр хэн боддог вэ? . . . Бурханы ажлын агуу бөгөөд төгс төгөлдөр



байгууллага дахь нэгж болох гэр бүлийн байгууллага болон энэ бүгд нь энэ амьдралд болон мөнхөд үргэлжлэх хувь тавилантайг хэн тунгаан боддог вэ?

*(Teachings: Joseph F. Smith, 385, 386)*

Одоо болон ирээдүйд бид бүхний хийх ёстой агуу ажлыг биелүүлэхэд бэлтгэхийн төлөө гэр бүл дотроо бие биедээ заахад, бие биенээ өсгөн хүмүүжүүлэхэд Бурхан биднийг адислах болтугай хэмээн би залбирч байна. Их Эзэн Есүс Христийн нэрээр, амен.